

ДААТГАЛЫН МЭРГЭЖЛИЙН ОРОЛЦОГЧИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль 2004 онд батлагдаж даатгалын мэргэжлийн оролцогчдын эрх зүйн байдлыг тус хуулиар тогтоон, тусгай зөвшөөрөл олгох, хянах үйл ажиллагааг Санхүүгийн зохицуулах хорооноос хэрэгжүүлж ирсэн.

Тус хуулиар даатгалын зуучлагч, төлөөлөгч, хохирол үнэлэгчдэд тусгай зөвшөөрөл олгох, хяналт тавих талаар зохицуулсан байдаг бөгөөд 2023 оны жилийн эцсийн байдлаар ердийн даатгалын зуучлагч 42 компани, давхар даатгалын зуучлагч компани 11, үүнээс 10 банк даатгалын зуучлагч, даатгалын хохирол үнэлэгч 24 компани, даатгалын 2416 төлөөлөгч даатгалын зах зээлд үйл ажиллагаа явуулж байна. Даатгалын хураамжийн орлого төвлөрүүлэлтийн харьцааг 2019-2023 оны байдлаар авч үзвэл дунджаар нийт хураамжийн 21.4 хувийг даатгалын зуучлагч, 27.5 хувийг даатгалын төлөөлөгч тус тус төвлөрүүлсэн. Тайлант хугацаанд 24 даатгалын хохирол үнэлэгч компани 83,4 тэрбум төгрөг бүхий 44,452 даатгалын хохирлыг үнэлж 4,3 тэрбум төгрөгийн даатгалын хохирол үнэлгээний орлоготой ажиллажээ.

Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл нь 10 бүлэг, 53 зүйлтэй бөгөөд даатгалын зуучлалын үйл ажиллагааг сайжруулах, практикт тулгамдсан асуудлуудыг оновчтой шийдвэрлэх замаар салбарын хөгжлийг олон улсын чиг хандлагад нийцүүлэх бодлогыг баримталж дараах өөрчлөлтүүдийг оруулсан.

1.“Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль” гэсэн нэр томъёог “Даатгалын зуучлалын тухай хууль” болгож өөрчлөхөөр тусгав. Ингэснээр даатгалын зуучлалын үйл ажиллагаатай холбоотой зохицуулалт буюу даатгалын брокер, банк-зуучлагч, даатгалын төлөөлөгчийн эрх зүйн харилцааг олон улсын туршлагад нийцүүлэн илүү ойлгомжтой тодорхой тусгаж, олон нийт болон салбарт оролцогчдын төөрөгдөл, буруу ойлголтыг багасгана.

Олон улсад даатгалын хохирол үнэлэгчийн үйл ажиллагаа нь даатгалын компанийн нөхөн төлбөр олгох үйл ажиллагааны нэг хэсэгт хамаардаг бөгөөд даатгалын компанийн ажилтан хохирлыг тооцох нийтлэг хандлага байдаг. Манай улсын хувьд даатгалын хохирол үнэлэгчийн үйл ажиллагаа нь Даатгалын тухай хуулиас тусдаа Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулиар зохицуулагдаж, тус хуулийн дагуу заавал тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд хохирол үнэлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх нь даатгуулагчийн хувьд цаг хугацаа, хөрөнгө санхүүгийн хүндрэл учруулдаг байсан тул олон улсын чиг хандлагад нийцүүлэн даатгалын хохирол үнэлэгчийн үйл ажиллагааг Даатгалын тухай хуулиар зохицуулж, хохирол үнэлэх ажлыг даатгалын компанийн ажилтан хийж гүйцэтгэх, үнэлгээтэй холбоотой маргаан гарсан тохиолдолд хөндлөнгийн үнэлгээчинд хандах эрхтэй байхаар зохицуулсан.

Харин даатгалын төлөөлөгчийн хувьд даатгагчийг төлөөлөхийн тулд даатгагчаас олгосон зөвшөөрлөөс гадна Хорооноос тусгай зөвшөөрөл авч байгаа нь төрд ачаалал үүсгэсэн, даатгалын төлөөлөгчид чирэгдэл учруулан ач холбогдолгүй зохицуулалт байгаа тул олон улсын туршлагад нийцүүлэн даатгалын төлөөлөгчийн тусгай зөвшөөрөл авах заалтыг хасаж Хорооноос эрх авдаг байхаар зохицуулсан.

2. Даатгалын зуучлалын үйл ажиллагааг даатгалын брокер, банк-зуучлагч, даатгалын төлөөлөгч гэсэн 3 этгээд хэрэгжүүлэх бөгөөд даатгалын брокер нь Хорооноос тусгай зөвшөөрөл авсан хуулийн этгээд, банк-зуучлагч нь Хорооноос тусгай зөвшөөрөл авсан банк, харин даатгалын төлөөлөгч нь 1 даатгагчийг төлөөлөх тохиолдолд иргэн, хэд хэдэн даатгагчийг төлөөлөх тохиолдолд хуулийн этгээд байх бөгөөд Хорооноос эрх авсан байна. Түүнчлэн даатгалын зуучлалын үйл ажиллагааг

илүү мэргэшсэн, төрөлжүүлсэн байдлаар хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэхийн тулд даатгалын брокерийн үйл ажиллагааг ердийн даатгалын брокер, амьдралын даатгалын брокер, давхар даатгалын брокер гэж 3 ангилсан. Олон улсын туршлагын дагуу банк даатгалын зуучлалын үйл ажиллагаа эрхлэх тохиолдолд банк-зуучлагчийн тусгай зөвшөөрлийг Хорооноос авахаар тусгасан. Даатгалын зуучлагчийн эрх үүргийг тодорхойлж, хариуцлагыг нэмэгдүүлэх, даатгуулагчийн эрх ашгийг хамгаалах, үнэн зөв бодит мэдээллээр хангах, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх зохицуулалтыг нэмж тусгасан.

3. Давхар даатгалын үйл ажиллагаанд даатгалын зуучлагч илүү мэргэшсэн байх практик шаардлагатай тул даатгалын брокерийн үйл ажиллагааг төрөлжүүлснээр давхар даатгалын брокерт тавигдах шаардлага тодорхой болж журмаар зохицуулах боломж бүрдэнэ. Мөн хамтарсан даатгалын үйл ажиллагаанд даатгалын брокерийн оролцох эрх зүйн орчинг бүрдүүлсэн.

4. Даатгалын олон улсын тулгуур зарчим /ICP/-тай уялдуулан даатгалын брокер нь үйл ажиллагаагаа найдвартай, оновчтой удирдлагаар хангаж, бизнесийн үйл ажиллагааны шинж чанар, цар хүрээ, цогц байдалд нийцэх үр дүнтэй засаглалын тогтолцоог бий болгож, мөрдөж ажиллахаар тусгасан. Мөн Хороо даатгалын салбарын дагаж мөрдвөл зохих зах зээлийн зохистой үйл ажиллагааны журмыг баталж, хэрэгжилтэд хяналт тавих бөгөөд даатгалын зуучлалын үйл ажиллагаанд оролцогч болон тэдгээрийн эрх бүхий албан тушаалтан түүнийг дагаж мөрдөх талаар зохицуулалт тусгагдсан. Даатгалын брокерийн засаглал, мэдээллийн ил тод байдал, мэргэжлийн ёс зүйтэй байдал нэмэгдсэнээр иргэд, олон нийт даатгалын салбарт итгэх итгэл нэмэгдэнэ.

5. Даатгалын брокер болон хэд хэдэн даатгагчийг төлөөлөх төлөөлөгчийн хувь нийлүүлсэн хөрөнгө нь хувьцаа эзэмшигчдийн хууль ёсны үйл ажиллагааны орлогоос бүрдүүлсэн мөнгөн хөрөнгөөс бүрдэх, хувь нийлүүлсэн хөрөнгийг зээлийн хөрөнгөөр бүрдүүлэхийг хориглох талаар болон даатгалын брокерийн хувьцааг бусдад худалдах, шилжүүлэх, барьцаалахад тодорхой хяналт тавих зохицуулалтуудыг тусгасан. Ингэснээр мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулах, эцсийн өмчлөгчийг тогтоох боломжтой болно.

6. Аливаа этгээд санхүүгийн үйлчилгээнд шинээр нэвтэрч буй технологид суурилсан шинэлэг бүтээгдэхүүн, үйлчилгээ, бизнес загварыг Сэндбоксын зохицуулалтын орчинд туршсаны үндсэн дээр даатгалын зах зээлд нэвтрүүлж, үйл ажиллагаагаа цахим хэлбэрээр эрхэлж болохоор тусгасан. Тус эрх зүйн орчныг бүрдүүлснээр даатгалын зуучлагчийн үйл ажиллагааны зардал буурах, борлуулалтын суваг нэмэгдэх, даатгалын үйлчилгээний чанар хүртээмж нэмэгдэх, түүнчлэн иргэд даатгалын үйлчилгээг авахад илүү хялбар болох боломж бүрдэнэ.

Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд дээрх томоохон өөрчлөлтүүдийг оруулснаар даатгалын салбарын гол борлуулалтын суваг болох даатгалын зуучлалын үйл ажиллагааг төрөлжүүлэх, эрх үүргийг нь тодорхой болгох, даатгуулагчид мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх, даатгалын үйлчилгээний ач холбогдлын талаарх олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх боломжтой гэж үзэж байна.